



МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА НЯМ-ОСОРЫН
УЧРАЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Дашцэрэнгийн ЭНХТҮВШИН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-71, Факс: 32-70-16
E-mail: Enkhtuvshin@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.12.17 № ЧУХ-03/14451
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин миний бие Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Д.ЭНХТҮВШИН

00000229



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Дашцэрэнгийн ЭНХТҮВШИН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-71, Факс: 32-70-16
E-mail: Enkhtuvshin@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.12.12 № 40X-03/14253
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай**

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин миний бие Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга болон холбогдох материалыг хавсаргав.

Хавсралт /6 хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Д.ЭНХТҮВШИН

00000211

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Д.ЭНХТҮВШИН

2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж, мөн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж, Хорин долдугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ. ..” гэж тус тус заасан.

Үндсэн хуульд заасан “засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх” зарчим нь засгийн бүх эрх ард түмнээс эх сурвалжтайг илэрхийлэх ба иргэд өөрсдийн дундаас сонгогдож, эрх мэдлийг шилжүүлэн авсан төлөөллийн байгууллага, төлөөлөгчөөрөө уламжлан төрийн үйл хэрэгт шууд оролцдог. Дээрх агуулгаар ард түмнээс эрх мэдлийг шилжүүлэн авсан төлөөллийн байгууллага, төлөөлөгч нь ард түмний хүсэл зоригийн илэрхийллийг дамжуулагчийн хувьд түүнд тулгуурлан эрх мэдлээ хэрэгжүүлж, өөрийн болон төрийн үйл ажиллагааг ард түмний хяналтад байлгах бүхий л бололцоог хуулиар нээж өгөх үүргийг энэхүү зарчмын хүрээнд хүлээдэг.

Иймээс Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн...гэж”, Хорин гуравдугаар зүйлийн 1-д “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэж тус тус заасны дагуу Улсын Их Хурал, төлөөллийн бүрэн эрхийг хэрэгжүүлж буй гишүүний шийдвэрийг иргэдэд боломжит богино хугацаанд мэдээлж, санал бодол, шүүмжлэлээ илэрхийлэх, хяналт тавих эрхээ хэрэгжүүлэх арга, механизмыг сайжруулах чиглэлд анхаарч ажиллах шаардлагатай. Түүнчлэн, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 21 дүгээр зүйлийн 3-д “Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой....” гэж заасанчлан төрийн эрх барих дээд байгууллагаас ил санал хураалтаар шийдвэрлэсэн асуудлын үр дүн эрх мэдлийн эх сурвалж ард түмэнд тухайн хугацаандаа ил тод хүрч байх ёстой.

Дээрх шалгуураар Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох зохицуулалтаас үзэхэд Улсын Их

Хурлаар аливаа асуудлыг шийдвэрлэсэн санал хураалтын дүн, гишүүн бүрийн санал ил тод, нээлттэй байх эрх зүйн орчин бүрэн хангагдаагүй байна.

Тодруулбал, Улсын Их Хурлын тухай 3.4-д “Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх, түүнчлэн бие даасан, нээлттэй, ил тод байх, ...”, гэж заасан боловч Улсын Их Хурлаас гарсан шийдвэр, гишүүдийн санал хураалтын дүн хэрхэн нээлттэй, ил тод байх процедурыг хуулиар журамлаагүй байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн хуулийн 38 дугаар зүйлд Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагааг мэдээлэх, сурвалжлах харилцааг ерөнхий зохицуулсан ч тухайн цаг үед төрийн эрх барих дээд байгууллага ямар асуудлыг авч хэлэлцэх, хэлэлцүүлгийн үр дүнг иргэдэд хэрхэн мэдээлэх талаар зохицуулаагүй. Мөн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 134 дүгээр зүйлийн 134.1-д “Чуулганы хуралдааныг телевизийн тусгай сувгаар шууд нэвтрүүлэх, түүнчлэн телевиз, радиод тусгай цаг гаргаж олон нийтэд сурталчлах, мэдээлэх ажлыг Тамгын газар зохион байгуулна” гэж ерөнхий нэг зохицуулалтаар мэдээлэх асуудлыг зохицуулж байна.

Улсын Их Хурал Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1-д заасан өөрийн онцгой бүрэн эрхэд хамаарах асуудлаас гадна улс орны бүх асуудлаар шийдвэр гаргах тул хууль тогтоох үйл ажиллагаа, хянан шалгах үйл ажиллагаа, гадаад харилцаа, хэвлэл мэдээлэл, ажлын хэсэг, олон улсын парламентын бүлгэм, хурал хэлэлцүүлэг зэрэг бүх асуудлыг нэг бүрчлэн сурвалжлах, мэдээлэх журмыг хуулиар тогтоох боломжгүй. Иймд үүнээс төлөөлөх бүрэн эрхтэй холбогдох Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1-д “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэж, Хорин долдугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ. ...” гэж заасанд шууд хамаарах чуулганы санал хураалтын дүн, гишүүний санал иргэдэд боломжит богино хугацаанд хүрэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай. Нөгөөтээгүүр, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны бүх шатны хэлэлцүүлгийн үр дүнг мэдээлэх журмыг хуулиар зохицуулах нь үр нөлөө, ач холбогдлын хувьд бага. Харин Улсын Их Хурлын чуулганаар хууль, тогтоолын төслийг хэлэлцэх эсэх болон эцсийн хэлэлцүүлгээс гарсан үр дүнг олон нийтэд мэдээлэх журмыг хуульчлах шаардлагатай байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 135 дугаар зүйлд Чуулганы хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнийг хадгалах журмыг хуульчилсан бөгөөд тус зүйлийн 135.3.3-д санал хураалтын дүн, санал өгсөн гишүүн бүрийн дэмжсэн, дэмжээгүй саналыг, 135.3.4-д тухайн хурлын ирцийг хурлын тэмдэглэлд тусгахаар заасан ч дээрх зохицуулалтын зорилго нь иргэдэд мэдээлэх шинжтэй бус албан хэрэг хөтлөх, хадгалах шинжтэй. Мөн хуулийн 136 дугаар зүйлийн 136.1-д “Хуралдааны тэмдэглэл болон дуу, дүрсний бичлэгийг чуулганы мэдээлэл бэлтгэж нийтлэх, хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээлэл, лавлагаа өгөх, маргаантай асуудлыг шийдвэрлэх зорилгод ашиглах ба Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулж олон

нийт танилцах бололцоог хангана” гэж заасан боловч дээр дурдсан хуралдааны чухал ач холбогдолтой хэсгийн мэдээлэл иргэдэд хүрдэггүй. Зарим тохиолдолд чуулганы хуралдааны санал хураалттай холбоотой мэдээллийг үзэмжээр ил болгох байдал ажиглагдаж байна.

Үндсэн хуулийн Хоринтавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж заасны дагуу энэхүү хуулийн төслөөр Улсын Их Хурлаар хэлэлцсэн асуудал, шийдвэрлэгдсэн байдал, Улсын Их Хурлын гишүүний байр суурь, гишүүний бүрийн санал тухайн өдрөө олон нийтэд нээлттэй, ил тод Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршина. Энэ нь Үндсэн хуульд заасан ардчилсан ёс, шударга ёсны зарчмыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтойгоос гадна иргэдийн төрд итгэх итгэлд эергээр нөлөөлнө.

1.2. Практик хэрэгцээ, шаардлага

Улсын Их Хурлын чуулганы хэлэлцүүлэг, санал хураалтын ил тод, нээлттэй байдал нь иргэдэд төрийн эрх барих дээд байгууллагаас гарсан шийдвэр, өөрийн сонгосон гишүүний байр суурь, өгсөн саналыг боломжит богино хугацаанд мэдэх эрхийг баталгаажуулж, төрд хяналт тавих боломжийг олгодог.

Улсын Их Хурлын тухай хуулийн хуулийн 38 дугаар зүйлд Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагааг мэдээлэх, сурвалжлах талаар ерөнхий зохицуулсан ч тухайн цаг үед төрийн эрх барих байгууллага ямар асуудлыг авч хэлэлцэх, хэлэлцүүлгийн үр дүнг буюу санал хураалтын дүнг иргэдэд хэрхэн мэдээлэх талаар зохицуулаагүй.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 135 дугаар зүйлд Чуулганы хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнийг хадгалах журмыг хуульчилсан. Тус зүйлийн 135.3.3-д санал хураалтын дүн, санал өгсөн гишүүн бүрийн дэмжсэн, дэмжээгүй саналыг, 135.3.4-д тухайн хурлын ирцийг хурлын тэмдэглэлд тусгахаар заасан ч дээрх зохицуулалтууд нь иргэдэд мэдээлэх шинжтэй бус албан хэрэг хөтлөх, хадгалах шинжтэй байна. Мөн хуулийн 136 дугаар зүйлийн 136.1-д “Хуралдааны тэмдэглэл болон дуу, дүрсний бичлэгийг чуулганы мэдээлэл бэлтгэж нийтлэх, хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээлэл, лавлагаа өгөх, маргаантай асуудлыг шийдвэрлэх зорилгод ашиглах ба Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулж олон нийт танилцах бололцоог хангана” гэж заасан боловч дээр дурдсан санал хураалттай холбоотой хэсгийн мэдээлэл иргэдэд нээлттэй хүрдэггүй. Дээрх зохицуулалтгүй байдлын улмаас шаардлагатай тохиолдолд иргэд төдийгүй Улсын Их Хурлын гишүүд ч санал хураалтын дүнтэй танилцах боломжгүй байдал үүсдэг.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.5-д “Гишүүн хуралдааны тэмдэглэлтэй аливаа хязгаарлалтгүйгээр танилцах эрхтэй бөгөөд төрийн нууцад хамрагдсан хуралдааны тэмдэглэлтэй танилцсан бол нууцыг задруулахгүй байх арга хэмжээг авна” гэж заасан. Гэвч практикт дээрх заалт нь тэмдэглэл хөтлөх журмын дагуу тэмдэглэл баталгаажсанаар танилцах эрх үүсэхээр хэрэгжиж байна.

Тодруулбал, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2021 оны 624 дүгээр захирамжаар Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тэмдэглэл хөтлөх журмыг баталсан. Тус журмын 2.1-д “Шинжээч хуралдааны товч тэмдэглэлийг тухайн хуралдаан дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор бэлэн болгоно” гэж, 4.2-д Референт бэлэн болсон хуралдааны товч тэмдэглэлийг ажлын 3 өдрийн дотор хянана” гэж, 4.3-д “Нэгжийн дарга энэ журмын 4.2-т заасны дагуу хянагдсан чуулганы нэгдсэн хуралдааны товч тэмдэглэлийг ажлын 2 өдрийн дотор хянана.” гэж, 4.8-д Шинжээч энэ журмын 4.7-д заасны дагуу хянагдсан нэгдсэн хуралдааны товч тэмдэглэлийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар албажуулахаар Ерөнхий нарийн бичгийн даргын туслахад ажлын 2 өдрийн дотор хүлээлгэн өгнө” гэж тус тус заасан бөгөөд санал хураалтын дүнг агуулсан чуулганы хуралдааны товч тэмдэглэл боловсруулагдахад ажлын 12 өдөр зарцуулахаар байна.

Мөн тус журмын 3.3-д Шинжээч яриаг бичвэр (voice to text)-т буулгах системийн тусламжтай дууны бичлэгээс хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл буулгах ба ажлын 5 өдрийн дотор эцэслэн хянаж бэлэн болгоно” гэж, 6.1-д Шинжээч нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл албажсан даруйд дэлгэрэнгүй тэмдэглэлийн хамт ажлын 1 өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулна” гэж тус тус заажээ. Дээрх журамд заасан хугацаануудыг нэгтгэн дүгнэхэд чуулганы хуралдааны саналын дүн нийт ажлын 13 өдрийн дараа буюу асуудлыг хэлэлцсэнээс 3 дах долоо хоногийн сүүлээр УИХ-ын албан ёсны цахим хуудаст байршихаар байна. Дээрх журамд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын тэмдэглэлийг албажуулах хугацааг зохицуулаагүй болохыг дурдах нь зүйтэй.

Дээрх журмын зохицуулалтын хүрээнд аливаа асуудлыг шийдвэрлэсэн санал хураалтын дүн тухайн асуудлын чуулганы хуралдаан болон олон нийтийн хэлэлцүүлэг дуусаж, ач холбогдлоо алдсанаас хойш хэлбэрийн төдий албан ёсны цахим хуудаст байршиж байна. Энэ нь Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 7-д “Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ...” гэж заасанд нийцэхгүй буюу иргэд эрхээ төлөөлүүлсэн гишүүний санал, байр суурь, хэлсэн үг нь өгсөн саналтай нь нийцэж буйг мэдэх боломж хязгаарлагдмал байна.

Парламентын засаглалтай бусад орны сайн жишгээс үзэхэд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундестагийн хуралдааны дэгийн 48 дах хэсэгт “Санал хураалтыг гар өргөх эсхүл босож зогсох, суудалдаа үлдэх гэсэн хэлбэрээр явуулна. 86-р зүйлийн дагуу хуулийн төслийн эцсийн санал хураалтыг босож зогсох эсхүл суудалдаа үлдэх хэлбэрээр явуулна” гэж заажээ. Мөн Санал тоолох 51 дүгээр зүйлийн 2-д Хуралдаан даргалагчийн шаардсаны дагуу Бундестагийн гишүүд чуулганы хуралдааны танхимаас гарна, дараа нь “санал хураалтын 3 хаалгаас” бусад хаалгийг хааж цоожилно. “Санал хураалтын онгорхой 3 хаалга” бүр дээр 2 хурлын хэрэг хөтлөгч зогсооно. Хуралдаан даргалагчийн дохиогоор Бундестагийн гишүүд “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” гэсэн 3 ангиллын хаалгаар танхимд эргэн орж ирэх бөгөөд хаалгаар орж буй гишүүдийн хурлын хөтлөгч нар чангаар дуудаж тоолно...” гэж заажээ.

Австралийн Холбооны Улсын Төлөөлөгчдийн танхимын хуралдааны дэгээр гишүүд Амаар, Хуваагдах аргаар, Нууцаар гэсэн 3 хэлбэрээр саналаа өгдөг байна. Үүнээс хуваагдах аргаар санал өгөхдөө дэгийн 129.с.(i) хэсэгт хуралдаан даргалагч санал хураалтыг танхимд зарласны дараа “Тийм” гэсэн хариултыг дэмжиж байгаа гишүүдийг хуралдаан даргалагчийн баруун тал руу “Үгүй” гэсэн хариултыг дэмжиж байгаа гишүүд зүүн тал руу нь очих” хэлбэрээр саналаа өгдөг байна.

Дээр дурдсан бусад улсуудын сайн туршлагуудаас үзэхэд хуралдааны санал хураалтын дүн, гишүүний өгсөн саналыг үйлд хөдлөлөөр нь илрэх байдлаар зохицуулж, иргэд гишүүн бүрийн саналыг мэдэх боломжтой хэлбэрээр зохицуулжээ.

Харин манай Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль болон холбогдох журмын дагуу санал хураалтын дүнг албан ёсоор цахим хуудсанд байршуулж, ил тод, нээлттэй болох процесс санал хураалтаас хойш ажлын 13 өдрийн дараа байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулж, 2 зүйлтэй байхаар тусгана.

Хуулийн төслөөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 134 дүгээр зүйлд заасан Чуулганы хуралдааныг нэвтрүүлэх, мэдээлэх журмыг боловсронгуй болгож, Чуулганы нэгдсэн хуралдаан болон байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх болон эцсийн хэлэлцүүлгийг явуулсан хуралдааны санал хураалтын дүн, санал өгсөн гишүүн бүрийн дэмжсэн, дэмжээгүй саналыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд тухайн өдөр байршуулахаар тусгана.

Хуулийн төслөөр Улсын Их Хурлаар хэлэлцсэн асуудлын чухал ач холбогдолтой хэсэг буюу тухайн асуудал дэмжигдсэн эсэх, эрхээ төлөөлүүлсэн гишүүний байр суурь, өгсөн санал зэрэг товч мэдээлэл тухайн өдрөө Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршина.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 134 дүгээр зүйлд зааснаар Чуулганы хуралдааныг нэвтрүүлэх, мэдээлэх ажлыг зөвхөн зурагт, радиогоор нэвтрүүлэх шинжтэй байсныг өөрчилж, хэлэлцүүлгээс гарсан үр дүнг тухайн цаг үед иргэдэд нээлттэй мэдээлж, олон нийтийг баталгаатай эх сурвалжаас мэдээлэл авах эрхийг хангана. Өөрчлөлтөөр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-д заасан Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуульд

зааснаар ардчилсан ёс, шударга ёс..., нээлттэй, ил тод байх..." зарчмыг бэхжүүлэхээс гадна иргэдийн төрд итгэх итгэлд эергээр нөлөөлнө.

Чуулганы хуралдаанаар асуудлыг хэлэлцүүлэх явцад гишүүдийн илэрхийлсэн байр суурь, өгсөн саналын нийцэл, уялдааг нэмэгдүүлэх бөгөөд Улсын Их Хурлын хариуцлага нэмэгдэж, гишүүдийн байр суурь саналаар нь илэрхийлэгдэж шийдвэрт шууд тусна. Санал хураалтын дүнг гишүүн бүрээр мэдэх боломж бүрдэнэ.

Улсын Их Хурал, төлөөллийн бүрэн эрхийг хэрэгжүүлж буй гишүүний шийдвэрийг иргэдэд боломжит богино хугацаанд мэдээлж, санал бодол, шүүмжлэлээ илэрхийлэх, хяналт тавих эрхээ хэрэгжүүлэх арга, механизмыг сайжруулна.

Улсын Их Хурлын гишүүний хуралдааны тэмдэглэлд хамаарах санал хураалтын дүн, гишүүдийн саналтай аливаа хязгаарлалтгүйгээр танилцах эрхийг журмаар хязгаарлаж байгааг хуульчилж, гишүүд төдийгүй олон нийт шийдвэр гарсан тухайн өдрөө танилцах боломжтой болно. Улмаар Улсын Их Хурал, байнгын хороодоос гарсан шийдвэрийн талаар буруу ташаа мэдээллээр олон нийтийг төөрөгдүүлэх явдал буурна.

Дөрөв. Хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдсэн орсон Олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад тусгагдсан хүн бүр улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхийн хүрээнд Улсын Их Хурлын хэлэлцүүлэг, оролцсон гишүүдийн санал хураалтын дүнг ил тод, нээлттэй болгоно.

Уг хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж, мөн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж, Хорин долдугаар зүйлийн 7-д “Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ. ..” тус тус заасан.

Үндсэн хуульд заасан “засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх” зарчим нь засгийн бүх эрх ард түмнээс эх сурвалжтайг илэрхийлэх ба иргэд өөрсдийн дундаас сонгогдож, эрх мэдлийг шилжүүлэн авсан төлөөллийн байгууллага, төлөөлөгчөөрөө уламжлан төрийн үйл хэрэгт шууд оролцдог. Дээрх агуулгаар ард түмнээс эрх мэдлийг шилжүүлэн авсан төлөөллийн байгууллага, төлөөлөгч нь ард түмний хүсэл зоригийн илэрхийллийг дамжуулагчийн хувьд түүнд тулгуурлан эрх мэдлээ хэрэгжүүлж, өөрийн болон төрийн үйл ажиллагааг ард түмний хяналтад байлгах бүхий л бололцоог хуулиар нээж өгөх үүргийг энэхүү зарчмын хүрээнд хүлээдэг.

Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллаг мөн...гэж”, Хорин гуравдугаар зүйлийн 1-д “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэж тус тус заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хэлэлцүүлэг, түүний үр дүн, төлөөллийн бүрэн эрхийг хэрэгжүүлж буй гишүүний саналыг иргэдэд ил тод, нээлттэй мэдээлж байх нь төрийн үүрэг мөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэж заасан бөгөөд Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар чуулганы хуралдааныг нэвтрүүлэх, мэдээлэх харилцааг хэт ерөнхий хуульчилсан бөгөөд уг зохицуулалтууд нь хэлэлцүүлгээс гарсан шийдвэр, санал хураалтын үр дүнг иргэдэд мэдээлэх бус нэвтрүүлэх, албан хэрэг хөтлөх, тэмдэглэлийг хадгалах шинжтэй байна.

Тодруулбал, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 134 дугаар зүйлийн 134.1-д “Чуулганы хуралдааныг телевизийн тусгай сувгаар шууд нэвтрүүлэх, түүнчлэн телевиз, радиод тусгай цаг гаргаж олон нийтэд сурталчлах, мэдээлэх ажлыг Тамгын газар зохион байгуулна” гэж заасан ганцхан зохицуулалтаар мэдээлэх ажлыг зохицуулж байна. Энэ зүйлийн хэрэгжилт нь чуулганы хуралдааныг телевизийн суваг, парламентын албан ёсны цахим хуудсаар шууд дамжуулах хэлбэрээр хэрэгждэг.

Харин иргэдийн гол анхаардаг асуудал нь аливаа хууль болон тогтоолын төсөл батлагдсан эсэх буюу санал хураалтын үр дүн, өөрийн сонгосон гишүүн болон бусад гишүүдийн өгсөн саналтай танилцах байдаг. Телевизээр шууд дамжуулах хэлбэр нь иргэдийн дээрх мэдэх эрхийг хангаж чаддаггүй. Шууд дамжуулалтыг бүтэн өдөр үздэг хүн ховор. Үзсэн ч санал хураалтын дүнг танилцуулж буй дэлгэц бүрэн бус гараад өнгөрдөг учир санал хураалтын үр дүнтэй танилцах боломжгүй байдаг. Улсын Их Хурлын гишүүд ч санал хураалтын дэлгэцийн зургийг авах байдлаар хуульд заасан санал хураалтын дүнтэй хязгаарлалтгүйгээр танилцах эрхээ хэрэгжүүлж байна.

2024 онд байгуулагдсан парламентын үйл ажиллагааны хугацаанд чуулганы хуралдааны санал хураалттай холбоотой хэд хэдэн асуудал үүссэн бөгөөд тухайн цаг үедээ шийдвэрлэгдээгүй өнгөрсөн. Учир нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 135 дугаар зүйлд Чуулганы хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнийг хадгалах журмыг хуульчилсан. Тус зүйлийн 135.3.3-д санал хураалтын дүн, санал өгсөн гишүүн бүрийн дэмжсэн, дэмжээгүй саналыг, 135.3.4-д тухайн хурлын ирцийг хурлын тэмдэглэлд тусгахаар заасан. Харин тэмдэглэл хөтлөх журмыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2021 оны 624 дүгээр захирамжаар баталсан журмаар зохицуулж байгаа бөгөөд тэмдэглэл бэлэн болоход урт хугацаа шаарддаг.

Тодруулбал, Тус журмын 2.1-д “Шинжээч хуралдааны товч тэмдэглэлийг тухайн хуралдаан дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор бэлэн болгоно” гэж, 4.2-д Референт бэлэн болсон хуралдааны товч тэмдэглэлийг ажлын 3 өдрийн дотор хянана” гэж, 4.3-д “Нэгжийн дарга энэ журмын 4.2-т заасны дагуу хянагдсан чуулганы нэгдсэн хуралдааны товч тэмдэглэлийг ажлын 2 өдрийн дотор хянана.” гэж, 4.8-д Шинжээч энэ журмын 4.7-д заасны дагуу хянагдсан нэгдсэн хуралдааны товч тэмдэглэлийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар албажуулахаар Ерөнхий нарийн бичгийн даргын туслахад ажлын 2 өдрийн дотор хүлээлгэн өгнө” гэж тус тус заасан бөгөөд санал хураалтын дүнг агуулсан чуулганы хуралдааны товч тэмдэглэл боловсруулагдахад ажлын 12 өдөр зарцуулахаар байна.

Мөн тус журмын 3.3-д Шинжээч яриаг бичвэр (voice to text)-т буулгах системийн тусламжтай дууны бичлэгээс хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл буулгах ба ажлын 5 өдрийн дотор эцэслэн хянаж бэлэн болгоно” гэж, 6.1-д Шинжээч нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл албажсан даруйд дэлгэрэнгүй тэмдэглэлийн хамт ажлын 1 өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулна” гэж тус тус заажээ. Дээрх журамд заасан хугацаануудыг нэгтгэхэд чуулганы хуралдааны саналын дүн нийт ажлын 13 өдрийн дараа буюу санал хурааснаас хойш 3 дахь долоо хоногийн сүүлээр Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршихаар байна.

Дээр дурдсан чуулганы хуралдааныг нэвтрүүлэх, мэдээлэх хуулийн зохицуулалт, арга хэрэгсэл нь Улсын Их Хурлын тухай хуулийн 3.4-д Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх, түүнчлэн бие даасан, нээлттэй, ил тод байх, ..., гэж, Улсын Их Хурлын чуулганы

хуралдааны дэгийн тухай хуулийн 3.1-д “Улсын Их Хурлын чуулганы хуралдаан хууль дээдлэх, нээлттэй, ил тод байх, .. зарчимд үндэслэнэ” гэж заасанд нийцэхгүй байна.

Иймд чуулганы хуралдааны чухал ач холбогдолтой хэсэг буюу хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх болон эцсийн хэлэлцүүлгийн санал хураалтын дүн, гишүүн бүрийн саналыг тухайн өдрөө товч мэдээлэл хэлбэрээр Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулан санал хураалтын ил тод, нээлттэй байдлыг хангах шаардлагатай байна.

Парламентын засаглалтай бусад улсын сайн туршлагаас үзэхэд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундестагийн хуралдааны дэгээр хуулийн төслийн эцсийн санал хураалтыг босож зогсох эсхүл суудалдаа үлдэх хэлбэрээр явуулдаг байна. Мөн саналыг тоолохдоо гишүүд чуулганы хуралдааны танхимаас гарч “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” гэсэн 3 ангиллын бичигтэй хаалгаар танхимд эргэн орж ирэх байдлаар санал хураалтын ил тод байдлыг хангадаг байна.

Мөн Австрали Улсын Төлөөлөгчдийн танхимын хуралдааны дэгээр гишүүд амаар, хуваагдах аргаар, нууцаар гэсэн 3 хэлбэрээр саналаа өгдөг. Үүнээс хуваагдах аргаар санал өгөхдөө “Тийм” гэсэн санал өгөх гишүүд хуралдаан даргалагчийн баруун талд “Үгүй” гэсэн санал өгөх гишүүд зүүн талд очих хэлбэрээр санал хураалтын ил тод байдлыг хангадаг байна. Ингэснээр Чуулганы хуралдаанаар асуудлыг хэлэлцүүлэх явцад гишүүдийн илэрхийлсэн байр суурь, өгсөн саналын нийцэл, уялдаа хангагдаж, иргэд гишүүдийн үйл хөдлөлөөр ямар санал өгснийг мэдэх боломжтой хэлбэрээр санал хураадаг байна.

Иймд энэхүү хуулийн төслөөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 134 дүгээр зүйлд заасан чуулганы хуралдааныг нэвтрүүлэх, мэдээлэх журмыг боловсронгуй болгож, чуулганы нэгдсэн хуралдаан болон байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх болон эцсийн хэлэлцүүлгийг явуулсан хуралдааны санал хураалтын дүн, санал өгсөн гишүүн бүрийн дэмжсэн, дэмжээгүй саналыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд товч мэдээлэл хэлбэрээр тухайн өдрөө байршуулахаар тусгана.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, ..., төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж, Хорин гуравдугаар зүйлийн 1-д “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэж, Хорин долдугаар зүйлийн 7-д “Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ...” гэж зааснаар Улсын Их хурлын нээлттэй, ил тод байдал сайжрах, сонгогчид ил санал хураалтаар шийдвэрлэсэн асуудлын үр дүнг богино хугацаанд авах, өөрийн сонгосон гишүүний байр суурь, өгсөн саналыг мэдэх эрхийг баталгаажуулж ард түмний засаглах эрхийг хангахад чухал нөлөө үзүүлэхээс гадна иргэдийн төрд итгэх итгэлд эергээр нөлөөлнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж, мөн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж, Хорин долдугаар зүйлийн 7-д “Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ. ..” гэж тус тус заасан.

Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллаг мөн...гэж”, Хорин гуравдугаар зүйлийн 1-д “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэж тус тус заасны дагуу Улсын Их Хурлын хэлэлцүүлэг, түүний үр дүн, төлөөллийн хүрэн эрхийг хэрэгжүүлж буй гишүүний саналыг иргэдэд ил тод, нээлттэй мэдээлж байх нь төрийн үүрэг мөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэж заасан бөгөөд Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар чуулганы хуралдааныг нэвтрүүлэх, мэдээлэх харилцааг хэт ерөнхий хуульчилсан бөгөөд уг зохицуулалтууд нь хэлэлцүүлгээс гарсан шийдвэр, санал хураалтын үр дүнг иргэдэд мэдээлэх бус нэвтрүүлэх, албан хэрэг хөтлөх, тэмдэглэлийг хадгалах шинжтэй байна.

Тодруулбал, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 134 дугаар зүйлийн 134.1-д “Чуулганы хуралдааныг телевизийн тусгай сувгаар шууд нэвтрүүлэх, түүнчлэн телевиз, радиод тусгай цаг гаргаж олон нийтэд сурталчлах, мэдээлэх ажлыг Тамгын газар зохион байгуулна” гэж заасан ганцхан зохицуулалтаар мэдээлэх ажлыг зохицуулж байна. Энэ зүйлийн хэрэгжилт нь чуулганы хуралдааныг телевизийн суваг, парламентын албан ёсны цахим хуудсаар шууд дамжуулах хэлбэрээр хэрэгждэг. Харин чуулганы хуралдаанаас гарсан шийдвэр, санал хураалтын үр дүнг албан ёсны баталгаатай эх сурвалжаар товч хэлбэрээр иргэдэд хүргэх шинжтэй зохицуулалт байхгүй байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 135 дугаар зүйлд Чуулганы хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнийг хадгалах журмыг хуульчилсан. Тус зүйлийн 135.3.3-д санал хураалтын дүн, санал өгсөн гишүүн бүрийн дэмжсэн, дэмжээгүй саналыг, 135.3.4-д тухайн хурлын ирцийг хурлын тэмдэглэлд тусгахаар заасан. Харин тэмдэглэл хөтлөх журмыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2021 оны 624 дүгээр захирамжаар баталсан журмаар зохицуулж байгаа бөгөөд тэмдэглэл бэлэн болоход урт хугацаа шаарддаг.

Тус журмын 2.1-д “Шинжээч хуралдааны товч тэмдэглэлийг тухайн хуралдаан дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор бэлэн болгоно” гэж, 4.2-д Референт бэлэн болсон хуралдааны товч тэмдэглэлийг ажлын 3 өдрийн дотор хянана” гэж, 4.3-д “Нэгжийн дарга энэ журмын 4.2-т заасны дагуу хянагдсан чуулганы нэгдсэн хуралдааны товч тэмдэглэлийг ажлын 2 өдрийн дотор хянана.” гэж, 4.8-д Шинжээч энэ журмын 4.7-д заасны дагуу хянагдсан нэгдсэн хуралдааны товч тэмдэглэлийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар албажуулахаар Ерөнхий нарийн бичгийн даргын туслахад ажлын 2 өдрийн дотор хүлээлгэн өгнө” гэж тус тус заасан бөгөөд санал хураалтын дүнг агуулсан чуулганы хуралдааны товч тэмдэглэл боловсруулагдахад ажлын 12 өдөр зарцуулахаар байна.

Мөн тус журмын 3.3-д Шинжээч яриаг бичвэр (voice to text)-т буулгах системийн тусламжтай дууны бичлэгээс хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл буулгах ба ажлын 5 өдрийн дотор эцэслэн хянаж бэлэн болгоно” гэж, 6.1-д Шинжээч нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл албажсан даруйд дэлгэрэнгүй тэмдэглэлийн хамт ажлын 1 өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулна” гэж тус тус заажээ. Дээрх журманд заасан хугацаануудыг нэгтгэхэд чуулганы хуралдааны саналын дүн нийт ажлын 13 өдрийн дараа буюу санал хурааснаас хойш 3 дахь долоо хоногийн сүүлээр УИХ-ын албан ёсны цахим хуудаст байршихаар байна.

Дээрх журмын дагуу чуулганы хуралдааны тэмдэглэлийг боловсруулж албан ёсны цахим хуудаст байрших хүртэл чуулганы хуралдааны санал хураалтын үр дүнтэй иргэд төдийгүй Улсын Их Хурлын гишүүд ч танилцах боломжгүй байна.

Ил санал хураалтын нээлттэй, ил тод байдлын талаар парламентын засаглалтай бусад улсын сайн туршлагаас үзэхэд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундестагийн хуралдааны дэгээр хуулийн төслийн эцсийн санал хураалтыг босож зогсох эсхүл суудалдаа үлдэх хэлбэрээр явуулдаг байна. Мөн саналыг тоолохдоо гишүүд чуулганы хуралдааны танхимаас гарч “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” гэсэн 3 ангиллын бичигтэй хаалгаар танхимд эргэн орж ирэх байдлаар санал хураалтын ил тод байдлыг хангадаг байна.

Мөн Австрали Улсын Төлөөлөгчдийн танхимын хуралдааны дэгээр гишүүд амаар, хуваагдах аргаар, нууцаар гэсэн 3 хэлбэрээр саналаа өгдөг. Үүнээс хуваагдах аргаар санал өгөхдөө “Тийм” гэсэн санал өгөх гишүүд хуралдаан даргалагчийн баруун талд “Үгүй” гэсэн санал өгөх гишүүд зүүн талд очиж зогсох хэлбэрээр санал хураалтын ил тод байдлыг хангадаг байна. Ингэснээр Чуулганы хуралдаанаар асуудлыг хэлэлцүүлэх явцад гишүүдийн илэрхийлсэн байр суурь, өгсөн саналын нийцэл, уялдаа хангагдаж, иргэд хэлэлцэж буй асуудал аль зөрүүтэй дэмжигдсэн эсхүл дэмжигдээгүй байгааг болон гишүүдийн үйл хөдлөлөөр ямар санал өгснийг мэдэх боломжтой хэлбэрээр санал хураадаг байна.

Иймд чуулганы хуралдааны үр дүнг товч мэдээлэл хэлбэрээр тухайн өдрөө Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулж, хэдэн цаг үргэлжилсэн шууд дамжуулалтаар бус товч бөгөөд тодорхой мэдээллээр хангах нь зүйтэй.

Нөгөөтээгүүр, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны бүх шатны хэлэлцүүлгийн үр дүнг мэдээлэх журмыг хуулиар зохицуулах нь үр нөлөө, ач холбогдлын хувьд бага. Харин Улсын Их Хурлын чуулганаар хууль, тогтоолын төслийг хэлэлцэх эсэх болон эцсийн хэлэлцүүлгээс гарсан үр дүнг олон нийтэд мэдээлэх журмыг хуульчлах шаардлагатай байна.

Хуулийн төслийн нэгдүгээр заалтаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 134 дүгээр зүйлд заасан чуулганы хуралдааныг нэвтрүүлэх, мэдээлэх журмыг боловсронгуй болгож, чуулганы нэгдсэн хуралдаан болон байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх болон эцсийн хэлэлцүүлгийг явуулсан хуралдааны санал хураалтын дүн, санал өгсөн гишүүн бүрийн дэмжсэн, дэмжээгүй саналыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд товч мэдээлэл хэлбэрээр тухайн өдрөө байршуулахаар тусгана.

Цахим хуудсанд байрших товч мэдээллийн хэлбэрийн төсөл;

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААН

Огноо: 2025.10.17 16:10:50

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж гэсэн санал хураалт явуулла.

Зөвшөөрсөн	72/114	63.2%	Татгалзсан	42/114	36.8%
Алтангэрэл.О	Алтаншагай.Н	Амарсайхан.С	Алдаржавхлан.Ж	Алтанхуяг.Н	Амарбаясгалан.Д
Ариунзана.А	Баасанжаргал.Х	Баатархүү.Ц	Аубакир.Т	Бадамсүрэн.М	Бат-Амгалан.З
Батбаяр.Д	Батболд.Р	Батжаргал.Ж	Батлут.Д	Батсүмбэрэл.Н	Баттулга.Х
Батняамдал.О	Батчимэг.П	Батшугар.Э	Батцэцэг.Б	Бат-Эрдэнэ.Б	Баярбаатар.Б
Бат-Эрдэнэ.Ж	Баярмаа.Ж	Баясгалан.Ж	Ганбаатар.А	Ганбаатар.Ж	Ганбат.Д
Бейсен.Б	Болормaa.Э	Булгантуяа.Х	Гантөмөр.Л	Дамдинням.Г	Дэлгэрсайхан.Б
Бум-Очир.Д	Бямбасүрэн.Ш	Бямбацогт.С	Жаргалан.Б	Жаргалсайхан.Д	Заяабал.Б
Галбадрах.Ж	Ганбаатар.Г	Ганбаатар.С	Лодойсамбуу.Ч	Мөнхбаясгалан.Л	Мандсайхан.З
Ганзориг.П	Ганмаа.Д	Ганхуяг.М	Нарантуяа-Нара.М	Номтойбаяр.Н	Одбаяр.Э
Ганхуяг.Х	Давхаасүрэн.Ц	Жавхлан.Б	Отгонбаяр.У	Очирбат.Г	Сайнзориг.П
Жангабыл.Х	Золжаргал.Ж	Зулхар.С	Сандаг-Очир.Ц	Сарнай.М	Үүрийнтуяа.Д
Идэрбат.Ц	Лувсанжамц.Г	Луудэг.С	Учрал.Н	Чинбүрэн.Ж	Энх-Амгалан.Л
Мандхай.М	Мөнхбаатар.П	Мөнхбат.Ц	Энхбаяр.Б	Энхбаяр.Ж	Энхтүвшин.Д
Мөнхсайхан.Т	Мөнхсай.Б	Мөнхтуяа.Ц	Эрдэнэбат.С	Эрдэнэболд.С	Эрдэнэбүрэн.Р
Найдалев.Б	Наранбаатар.Н	Наранбаяр.П			
Номин.Ч	Номинчимэг.О	Одонтуяа.С			
Оюун-Эрдэнэ.Л	Пүрэвдаваа.Д	Пүрэвдорж.Б			
Рэгдэл.Д	Саранчулуун.О	Соронзонболд.Л			
Сэддорж.Р	Туваан.Ц	Түвшин.Б			
Туяга.Б	Тэмүүжин.Х	Тэмүүлэн.Г			
Ундраа.А	Ундраа.Ч	Уянга.Б			
Уянгахишиг.Г	Хосбаяр.Г	Харлэн.Б			
Цогтбаатар.Д	Цогтгэрэл.О	Шижир.Ө			
Энхтасан.А	Энхтуяа.Д	Энхцэцэг.М			

Мөн хуулийн төсөлд нууц санал хураалт болон хаалттай хуралдаанаар хэлэлцсэн чуулганы хуралдааны товч мэдээллийг Улсын Их Хурлын албан ёсны цахим санд байршуулах заалт хамаарахгүй байхаар тусгалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагааг мэдээлэх, сурвалжлага хийх хэсэгт чуулганы хуралдааны хэлэлцүүлгээс гарсан үр дүнг дэгийн тухай хуульд заасны дагуу мэдээлэх агуулгатай заалт нэмнэ.Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, ..., төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж, Хорин долдугаар зүйлийн 7-д “Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ...” гэж зааснаар Улсын

Их хурлын нээлттэй, ил тод байдал сайжрах, сонгогчид ил санал хураалтаар шийдвэрлэсэн асуудлын үр дүнг богино хугацаанд авах, өөрийн сонгосон гишүүний байр суурь, өгсөн саналыг мэдэх эрхийг баталгаажуулж ард түмний засаглах эрхийг хангахад чухал нөлөө үзүүлэхээс гадна иргэдийн төрд итгэх итгэлд эергээр нөлөөлнө.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ
ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 134 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 134.2, 134.3, 134.4, 134.5, 134.6, 134.7 дахь хэсэг нэмсүгэй:

“134.2. Чуулганы нэгдсэн хуралдаан болон байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх болон эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бол хуралдааны товч мэдээллийг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд тухайн өдөр байршуулна.

134.3. Энэ зүйлийн 134.2-д заасан хуралдааны товч мэдээлэлд дараах зүйлийг тусгана.

134.3.1. хуралдаанаар хэлэлцсэн асуудал;

134.3.2. хуралдааны ирцийн мэдээ /тоо, хувиар/;

134.3.3. хуралдаан эхэлсэн, завсарласан, хойшилсон, дууссан он, сар, өдөр, цаг, минут;

134.3.4. санал хураасан томьёолол, санал хураалтын дүн /тоо, хувиар/, санал өгсөн гишүүн бүрийн дэмжсэн, дэмжээгүй саналын тоо;

134.3.5. техник, хэрэгслээс шалтгаалсан болон бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас алдаатай санал өгсөн гишүүний тухайн асуудлыг дэмжсэн, дэмжээгүйгээр хуралдааны тэмдэглэлд тусгуулахаар гаргасан санал.

134.4. Тухайн өдөр чуулганы нэгдсэн болон байнгын хорооны хуралдаанаар хэд хэдэн асуудлын хэлэлцэх эсэх болон эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бол хэлэлцсэн асуудал тус бүрээр товч мэдээллийг бэлтгэн мэдээлнэ.

134.5. Нууц санал хураалт явуулсан хуралдааны товч мэдээлэлд энэ зүйлийн 134.3.4-д заасан мэдээллээс зөвхөн санал хураалтын дүнг тусгана.

134.6. Хаалттай хуралдаанаар хэлэлцэх аливаа асуудалд энэ зүйлд заасан мэдээлэх журам хамаарахгүй.

134.7. Хуралдааны товч мэдээлэлд агуулсан тоо, мэдээлэл энэ хуулийн 135.1-д заасан хуралдааны дэлгэрэнгүй болон товч тэмдэглэлтэй зөрсөн тохиолдолд хуралдааны тэмдэглэлийг баримтална.”

2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 134 дүгээр зүйлийн гарчгийн “мэдээлэх журам” гэснийг “гарсан үр дүнг мэдээлэх журам” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 38.4 дэх хэсэг нэмсүгэй:

“38.4.Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээлэх ажлыг Тамгын газар зохион байгуулах бөгөөд хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх болон эцсийн хэлэлцүүлгийн мэдээллийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуулийн 134 дүгээр зүйлд заасан журмын дагуу мэдээлнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг